

BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

2022 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



SUSTAINABLE
DEVELOPMENT **GOALS**
17 GOALS TO TRANSFORM OUR WORLD



**МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ЭНХГЭРЭЛ**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛЫН МЭНДЧИЛГЭЭ

2020 оноос үргэлжилсэн Ковид-19 цар тахлын үр дагавар болон 2022 оны 02 сарын 24-ний өдрөөс эхэлсэн ОХУ болон Украин улс хоорондын дайны нөхцөл байдлын улмаас 2022 эхний улиралд дотоодын эдийн засаг, тэр дундаа барилга бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлүүд бий болгосон ч 2022 оны эхний улирлын дунд үеэс үйл ажиллагаанууд эрчимжиж эхэлсэн билээ. "Монгол Базальт" ХК-ийн хувьд энэ хугацаанд ажилтнуудаа тогтвортой ажлын байраар хангах, орлогын эх үүсвэр хангамжийг бууруулахгүй байх бодлогыг нэн тэргүүнд барьж ажилласан юм.

Компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үзүүлэх сөрөг хүчин зүйлүүд болох тээвэр ложистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар барилгын дулаан тусгаарлагч байгальд ээлтэй чулуун хөвөн хавтан үйлдвэрлэж эхний хагас жилд 2021 оны жилийн үйлдвэрлэлийн 50 хувьтай тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн байна.

2022 онд зах зээлд гаргасан Монгол Базальт ХК-ийн "ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО"-ын хүрээнд хэрэгжүүлж буй "НОГООН ТӨСӨЛ" бүхий GROWOOL бүтээгдэхүүн нь байгаль орчин, хүнсний үнийн өсөлт, хил гаалиас шалтгаалсан хүнсний хомсдол зэрэг асуудлуудтай бодитой тэмцэх ногоон инноваци юм.

Цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны онцгой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг бид нэн тэргүүний зорилго болгон ажиллаж үйл ажиллагааны зардлын хэмнэлтийн горимд шилжин, борлуулалтын орлогоо 2,7 дахин, өсгөсөн амжилттай байна. Үндэсний цор ганц үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлүүд нэмэгдэж үүнийг дагаад санхүүгийн үр дүн үзүүлэлтүүд улам бүр сайжирч хэрэглэгчид болон нийт хувьцаа эзэмшигчидийнхээ хүлээлтийг давуулан биелүүлэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна.



Компанийн тухай



Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Үйл ажиллагааны
чиглэл:

Чулуун хөвөнгийн
үйлдвэр, үйлдвэрийн
хучин чадал: Цагт 1.8 тн

Байгуулагдсан огноо:

2007

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар
хот, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Фламинго тауэр,
403
ТООТ

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Утас, и-мэйл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn



Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн дарга:

Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

75



Хувьцааны мэдээлэл

Хувьцааны симбол
код:

MSE:MBW / 544

МХБиржид
бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан
хувьцаа:

56,417,000 ширхэг

Компанийн танилцуулга

Монгол Базальт ХК нь улсын хөгжлийн түүчээ, эдийн засгийн тэргүүлэх чиглэл бүхий металл бус боловсруулах хүнд үйлдвэрлэлийн салбарт өндөр техник технологийн Евро-стандартын галын аюулгүй байдлыг хангах онцгой тусгаарлагч бүтээгдэхүүний үйлдвэрийг нутагшуулан барилга, дэд бүтэц, эрчим хүчний салбаруудад нийлүүтэн үйл ажиллагаа явуулж байна.

Манай чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал нь ОУ-ын галын А1 зэрэглэлтэй стандартад МУ-аас цор ганц нийцдэг тусгай бүтээгдэхүүн бөгөөд байгаль орчин, хүн нийгэмд ээлтэй, нүүрс хүчлийн хий, түүний ул мөрийг бууруулах, эрчим хүч, дулааны хамгийн их хэмнэлт үүсгэх, чанарын эрсдэлгүй үндэсний тогтвортой бүтээн байгуулалтуудыг дэлхийн чанар үзүүлэлтэд нийцүүлж буй стратегийн онц чухал бүтээгдэхүүн юм.

Эрхэм зорилго

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг эрүүл тав тухтай, байгаль дэлхийд ээлтэй, барилга хийцийн эрсдэлгүй, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх, ямагт өсөх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгохоор зорьж байна.



Accelerate Digital Transformation




Nurture Innovation Culture



Gain Optimal Impact Public Contribution



Компанийн бүтэц, засаглал



Монгол Базальт ХК-ийн хувьд компанийн засаглал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үнэ цэнэтэй, үр өгөөжтэй болгохын тулд нийт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талууд хоорондын итгэлцэл, бүхий л харилцаа, үүрэг хариуцлагын зохистой харьцааг тогтооход чухал ач холбогдолтой үйл явц, тогтолцоо юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан компанийн засаглалын кодексын дагуу засаглалын үнэлгээ хийлгэж, сайжруулах хөтөлбөрийг ТУЗ-ийн 2022 оны 06 сарын 30-ны өдрийн .. тоот тогтоолоор батлуулж, биелэлтийг ханган ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

2022 оны 4 сарын 22-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн баталж, 2022 оны бизнес төлөвлөгөөг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан.

Компанийн дүрэм ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ улиралд нэг удаа хуралдаж, эдийн засаг, ашигт ажиллагаанд ач холбогдол бүхий шийдвэрүүдийг цаг тухайд нь гарган ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг



Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл



Дэд захирал
П.Батмөнх



Дотоод аудитор
Ц.Байгалмаа



Үйлдвэрийн дарга, Ерөнхий
технологич
П.Баасан-Очир



Ерөнхий менежер
Д.Сайнбаатар



Ерөнхий нягтлан бодогч
Б.Болортуяа



Ерөнхий инженер
Х.Батдэлгэр




Ерөнхий механик инженер
Ж.Сүхбаатар

Хүний нөөц




2019-2021 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 30% байгаа бөгөөд шинээр фибер арматурын үйлдвэр ашиглалтанд оруулсанаар ажлын байрны тоо хэмжээ 2 дахин өснө. Нийт ажилтаны 90% нь дээд боловсролтой, 70% нь 3 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар цалингийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36% өссөн байна.

Боловсролын түвшин



Ажилласан жил



Ажилчдын хүйсийн харьцаа



Ажиллах хүчний харьцуулалт



Бүтээгдэхүүн



BASALTWOOL
ЧУЛУУН ХӨВӨН
ХАВТАН




BASALTWOOL
HOUSE ROCK
ХУЙЛМАЛ ХӨНЖИЛ



БАЗАЛИТ FLEX
УЯН, ЗӨӨЛӨН
АКУСТИК ХАВТАН



GROWOOL
ГИДРОПОНИК
ХӨРСГҮЙ
ТАРИАЛАЛТ



BASALTWOOL
ХЭСЭГЧЛЭН
УГСРАХ СЭНДВИЧ



BASALTWOOL
ТРИОБЛАИТ СУ
**ШУГАМ ХООЛОЙН
ДУЛААЛГА**



**BASALT ФАЙБЕР
АРМАТУР**



SDG 17:
Үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох.

Тогтвортой хөгжлийн зорилтууд



SDG 13:
Нүүрс хүчлээн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ



ТҮҮХИЙ ЭД



SDG 12:
Хог хаягдалгүй үр ашигтай үйлдвэрлэл.



SDG 7:
Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад янзвар шилжлэл хийж эрчим хүчний хэмжээг багасгах.



SDG 6:
Ашигласан усны шөвгийн сав байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт саврал усны хэрэглээг багасгах.



SDG 13:
Үйлдвэрийн гарах хоолойгуудыг филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлээн хийн ялгарлыг стандартын багасгах, хүргэсэн.



SDG 8:
Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулах.



SDG 9:
Бат бөх галд тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх.



SDG 8:
Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих.



SDG 13:
Нүүрсөрөгчийн хэмжээг багасгах барилга байгууламж, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх.



SDG 11:
Оролгод нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмжээг багасгах.



SDG 7:
Эрчим хүчний хэмжээг багасгах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.



SDG 6:
Барилгын усны хэрэглээг багасгах.



SDG 2:
Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох.



SDG 3:
Дуу чимэний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх.

Тогтвортой хөгжлийн зорилт.
 Бүтээгдэхүүний хэмжүүр.

Онцлох үйл явдал



Монгол Базальт ХК-ийн философи төгтвортой хөгжлийн зорилтуудтай нягт уялдаа холбоотой. Бид 2022 онд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн ялгаруулж буй нүүрсхүчлийн хий болон агаар орчны бохирдлыг бууруулах дахин дулаалгын төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхэц болох ЭСКО зөвшөөрлөө энэ эхний улиралд хүлээн авлаа.

Үзэсгэлэн арга хэмжээ

Улаанбаатар барилга 2022 үзэсгэлэнд оролцон шинээр хэрэгжүүлж буй арматур, хэсэгчлэн угсрах сэндвич хавтан бүтээгдэхүүний мэдээллийг олон нийтэд танилцууллаа.



"Ногоон хот миний ирээдүй" сэдэвт гар зургийн уралдааныг бага насны хүүхдүүдийн дунд ажилттай зохиож байгууллаа.



Амжилтууд

Монгол Базальт ХК нь тогтвортой хөгжлийн 17 зорилгоос 11-ыг нь эрэмбэлэн манай бизнест хамгийн их ач холбогдолтой, ахиц дэвшил, ололт амжилтыг хэмжих шалгуур болгон ашиглаж байна.

2014 онд гэр хорооллын айлуудын дахин дулаалгын аянууд санаачлан зохион байгуулснаас эхлүүлээд, 2018 онд олон нийтэд танилцуулсан үйл ажиллагааны тайландаа Тогтвортой хөгжлийн бүлэг нэмж оруулан, цаашид олон төсөл хөтөлбөрүүд, арга хэмжээ, дотоод/гадаадын илтгэл танилцуулга бүрийнхээ төвд нь SDG-ийн үзэл баримтлалуудыг гол зорилгоо болгон шингээж ирсэн ба 2022 оны эхний улиралд тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэн олон нийтэд танилцуулаад байна.

Цагийн хүрдийн баатрууд-2021: Байгальд ээлтэй үйлдвэрлэл эрхлэгч байгууллагаар Монгол Базальт ХК шалгарлаа.



Ногоон төсөл GROWOOL



Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно. Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт алыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээлэлийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна.



Тогтвортой хүнсний үйлдвэрлэл

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.

2 ӨЛСГӨЛӨНГ
ЗОГСООХ



6 БАТАЛГААТ УНДНЫ УС
АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖААР
ХАНГАХ



15 ХУУРАЙ ГАЗРЫН
ЭКО СИСТЕМИЙГ
ХАМГААЛАХ



Онцлох үйл явдал


#ХОЖЛЫН_ТӨЛӨӨ_БАГЛАА_ДЭМЖЬЕ уриан дор АХБХ-НЫ АЗИЙН ЦОМЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЭ-Н-ийг дэмжигч байгууллагаар хамтран ажиллалаа.



Хамтын ажиллагаа

GIZ германы түншлэлийн сургалтын хүрээнд тус компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл Герман улс дахь чулуун хөвөн ашиглаж буй барилгууд дээр очиж танилцаж, зах зээлийн хэрэглээ, үйлдвэрийн үйл ажиллагааны сургалт семинарт оролцож туршлага солигцлос.

Франц улсад төвтэй Жерэс олон улсын төрийн бус байгууллагатай 5000 айл дахин дулаалах төсөл дээр хамтран ажиллах гэрээ байгууллага.



Шинэ бүтээгдэхүүний туршилт, судалгаа

Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоо гүйцэтгэх захирал Г.Цэрмаа, "Керамик Урлал" лаборатори, МУ-ын Зөвлөх инженер, ШУТИС-ХШУС докторант Д.Алганцэцэг, Монгол Базальт ХК гүйцэтгэх захирал А.Энхгэрэл нар "ХАМТРАН АЖИЛЛАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ"-нд гарын үсэг зурлаа.

- 1.Базальт чулуун хөвөн үйлдвэрлэлийн язцад гардаг хөвөн шлак болон хөвөн үртэсээр ТЕРМОБЛОК хийх, массын найрлага тогтоох туршилт судалгаанд үндэслэн үйлдвэрлэлийн дамжлага цех байгуулж иргэдэд Эрчим хүчний хэмнэлттэй дулаалгатай дүүргэгч ТЕРМОБЛОК бүтээгдэхүүн гаргах
- 2.Фибрабазальтын туршилт судалгаа, хөндлөнгийн лаборатори шинжилгээ дүгнэлт, массын найрлагын тогтоох туршилт судалгаа хийх
- 3.Монгол Базальт ХК-ийн залуу технологич Б.Ану болон лабораторын эрхлэгч Г.Мөнхбайгалмаа нарын магистрын ажлыг удирдан зохион байгуулж, хамгаалуулах зэрэг ажлууд гэрээнд тусгагдаж Монгол Базальт ХК санхүүжүүлж ажиллахаар боллоо.



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШУТИС БАС-ЫН ОЮУТНУУДАД ҮЙЛДВЭРЭЭ ТАНИЛЦУУЛЛАА.



Эрдэнэт үйлдвэрийн дулааны цахилгаан станцын 30 жил болсон дулаан дамжуулах шугамын дулаалгын ажлыг хийж гүйцэтгэлээ.



2022 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсанаар эхний хагас жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу 1300 тн хөвөн буюу 105,000 орчим боодол бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.

Оёмол хөнжлийн хэсэгт Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Дулааны цахилгаан станцын захилгаар 2807 ширхэг буюу нийт 3369 метр базальт файбер угсан торон гадаргуутай хуйлмал хөнжил бэлтгэн нийлүүлээ.

Термобазальт шугам хоолойн дулаалгын цехд нийт 1672 метр шугам, яндан хоолойн дулаалга хийж гүйцэтгэлээ.

Технологийн алба ХАБЭАА-тай хамтран Хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрийн ослын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт ажилчдыг хамрууллаа.



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монгол Базальт ХК нь 2022 оны эхний хагас жилд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажиллалаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг түүхий эд материалын тээвэр болон сэлбэг хэрэгслийн үнийн өсөлтөөс үүдэн нэмэгдсэн хэдий ч борлуулалтын орлогыг өмнөх оны мөн үеэс 2.7 дахин буюу 3,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.


Борлуулалтын орлого /цэвэр/



Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%

Ногдол ашгийн өсөлт /₮/




Борлуулалт



Монгол Базальт ХК нь 2022 оны эхний хагас жилд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд 105,000 орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 37%-ийг базальт лайт, 21%-ийг базальт хауз, 33%-ийг базальт вент фасад, 4%-ийг базальт техно, 5%-г базальт техно стандарт марк тус тус эзэлж байна.



Хувьцааны мэдээлэл



ХУВЬЦААНЫ ХАНШ

Хаалтын ханш
/2022.06.30/

+14.24₮

172.41₮




186.65₮

Өмнөх ханш
/2021.12.31/

Хувьцаа эзэмшигчид


- 5%-иас дээш хувьцаа эзэмшигчид
- 5%-иас доош хувьцаа эзэмшигчид



Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 238.19₮, доод ханш нь 172.19₮ бөгөөд 2022 оны нэг эхний хагас жилийн хаалтын ханш 186.65₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 182 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 1.09 сая ширхэг хувьцааг 225.927 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Хувьцааны ханшийн график /2022.01.01-2022.06.30/



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

МОНГОЛБАЗАЛТ ХК

2022 оны 06 сарын 30 өдөр

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(млн.төг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 06-р сарын 30
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	5,964,104.88	5,442,346.66
1.1.2	Дансны авлага	4,887.22	446,765.90
1.1.3	Татвар, Н.ДШ-ийн авлага	155.42	157.11
1.1.4	Бусад авлага	114,042.20	144,816.52
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	0.00
1.1.6	Бараа материал	2,425,087.30	3,797,840.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	653,897.65	1,754,273.51
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүтэц хөрөнгө)		
1.1.10			
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,162,174.67	11,586,244.61
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,562,794.68	15,726,897.27
1.2.2	Биег бус хөрөнгө	13,503,921.06	12,987,777.06
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зоригдолттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,066,715.74	28,714,674.33
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38,228,890.41	40,300,918.95
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богшино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	181,381.67	124,544.75





САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2.1.1.2	Цаливгийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	1,104,502.92	1,017,754.66
2.1.1.4	Н.Ш-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богшино хугацаат зээл	5,900,141.67	5,423,026.70
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ноогдол ашигийн өглөг	130,323.43	606,154.49
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,054,622.74	3,314,831.42
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	180,328.32	359,538.58
2.1.1.10	Бусад богшино хугацаат өр төлбөр	1,405.58	1,142.75
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богшино хугацаат өр төлбөрийн дүн	8,552,706.32	10,846,990.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,552,706.32	10,846,990.34
2.3	2. Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн		
2.3.2	- хувийн	5,641,700.00	5,641,700.00
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хугацаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	20,509,765.23	20,509,765.23
2.3.6	Хөрөнгийн дахин үнэмлээний нэмэгдэл	1,429,273.95	1,429,273.95
2.3.7	Гадаад валютын гөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алхагдал)	2,095,444.91	1,873,189.43
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	29,676,184.09	29,453,928.60
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	38,228,890.41	40,300,918.95

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

МОНГОЛ БАЗАЛТ ХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

2022 оны 06 сарын 30 өдөр

(млн.төг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 06-р сарын 30
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,485,330.45	5,826,117.25
2	Борлуулалтын өртөг	7,488,968.62	3,844,478.21
3	Нийт ашиг (алдагдал)	3,996,361.82	1,981,639.04
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	77,088.12	4,124.93
6	Ногдол ашгийн орлого	-	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	0.00
8	Бусад орлого	3,373.29	2,493.08
9	Борлуулалт маркетингийн зардал	733,235.30	791,927.48
10	Ерөнхий ба удирдлагын зардал	694,761.58	349,625.12
11	Санхүүгийн зардал	507,235.76	102,704.87
12	Бусад зардал	287,401.45	4,063.75
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,138.86	84,409.77
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө сруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,856,328.02	824,345.61
19	Орлогын татварын зардал	254,261.98	82,434.56
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,602,066.04	741,911.05
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,602,066.04	741,911.05
23	Бусад дэлгэрэнгүй орлого	1,429,273,949.00	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	1,429,273,949.00	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	1,430,876,015.04	741,911.05
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-





Thank You.

Visit Us

www.Basaltwool.mn

Contact us

75114444